

## **МОНГОЛ-ХЯТАДЫН НАЙРАМДЛЫН НИЙГЭМЛЭ- ГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

(Монгол-Хятадын найрамдлын нийгэмлэгийн 30 жилийн ойг тохиолдуулан тус сэтгүүлийн редакци МХНН-ийн дарга н. Б. Мягмаржаваас авсан ярилцлагыг нийтлэв).

### **Б. МЯГМАРЖАВ**

БНХАУ-ыг тунхагласны 9 жилийн ойг тохиолдуулан Монголын соёл урлаг, шинжлэх ухаан, олон нийт, үйлдвэр аж ахуйн байгууллагуудын ажилтнуудын санаачлагаар 1958 оны 9 дүгээр сарын 30-нд Монгол Хятадын найрамдлын нийгэмлэг (МХНН) байгуулагдсан билээ. Мөн өдөр БНХАУ-д Хятад-Монголын найрамдлын нийгэмлэг байгуулагдсан байна. Хоёр орны найрамдлын нийгэмлэг нь Монгол-Хятадын ард түмний найрамдал, хамтын ажиллагаа болон сайн хөршийн харилцааг хөгжүүлэн бэхжүүлэх үйлст ихээхэн тус дөхөм үзүүлж ирсэн юм.

МХНН хоёр орны ард түмний социалист бүтээн байгуулалтын ололт амжилтыг харилцан сурталчлах, харилцан ойлголцох явдлыг гүнзгийрүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж төлөөлөгчдөө солилцох, гэрэл зургийн самбар, үзэсгэлэн гаргах, сонин сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэх зэргээр ажиллаж байв. Мөн үндэсний баярыг тохиолдуулан найрамдлын 10-20 хоногийг зарлан явуулж, олон төрлийн арга хэмжээг зохиож байв. Энэ бүхэн нь Монгол-Хятадын ард түмний эрх ашигт бүрэн нийцэж байлаа. Гэвч богино хугацаанд хоёр нийгэмлэгийн үйл ажиллагаа, хоорондын харилцаа хомсдон багассан үе гарсанд бид бүхэн харамсаж байдаг юм.

Монгол-Хятадын ард түмэн эв найрамдал, сайн хөршийн харилцаатай байх хүсэл эрмэлзлэлтэй байсан учраас хоёр нийгэмлэгийн хоорондын харилцааг сэргээх нь энэ нийтлэг эрх ашигт тус дөхөм болохыг харгалзан МХНН-ийн тэргүүлэгчдийн өргөтгөсөн хурал 1984 онд болж нийгэмлэгийн үйл ажиллагааг идэвхжүүлэх шийдвэр гаргав. Бүх Хятадын гадаадтай найрамдах ардын нийгэмлэгээс МХНН-ийн энэ санаачлагад баяр хүргэсэн бөгөөд МХНН, Хятадын ЭСЯ-ны хооронд уулзалт хийж хоёр нийгэмлэгийн харилцааг сэргээн хөгжүүлэх эрмэлзлэлтэй байгаагаа илэрхийлсэн юм.

МХНН-ээс ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэнтэй хамтран нийгмийн зүтгэлтэн, эрдэмтэн, зохиолч зэрэг Хятадын нэрт хүмүүсийн ойг тэмдэглэж байв. ХХ зууны Хятадын нэрт зохиолч Лао Шэгийн мэндэлсний 85 жилийн ойгоор «Утга зохиол, урлаг» сонинд түүний үйл амьдралыг харуулсан өгүүллийг нийтлүүлэв.

БНХАУ-ыг тунхагласны ойг тохиолдуулан жил бүр МЭТНБХ-ны гүйцэтгэх хороо, МХНН-ээс эрхлэн үдэшлэг концерт зохиож тэмдэглэж ирэв. Хятадын чөлөөт барилдааны бөхчүүд, улаан навч чуулганы жүжигчид, циркийн жүжигчид, уран зургийн болон гар урлалын үзэсгэлэнгийн зураач, уран бүтээлчид манай оронд ирэхэд нь МХНН уулзалт хийв.

Монголын зарим тогтмол хэвлэлийн Хятад-Монголын найрамдлын нийгэмлэгт байнга илгээж байсны дээр ном зохиол, дуу хөгжмийн бичлэг солилцох ажил хийж байна. Манай нийгэмлэгийн зохиосон эдгээр

арга хэмжээ нь Монгол-Хятадын ард түмний хоорондын харилцааг өргөжүүлэн хөгжүүлэхэд бага боловч тус дөхөм болсон гэж үзэж баяртай байна.

МХНН тус улсад суугаа БНХАУ-ын ЭСЯ-ны дипломат ажилтан нарыг өөрийн ард түмний аж амьдралтай танилцуулах зорилгоор МХНН ийн нэрэмжит Төв аймгийн Заамарын нэгдэлд зочлуулав.

МХНН, Дорнодахины судлалын хүрээлэн хамтран Зүүн хойд Хятад ба Өвөр Монголыг чөлөөлсний 40 жилийн ойд зориулан хийсэн гэгээрлийн бага хуралд Хятадын ЭСЯ-ны ажилтан нар оролцож үг хэлсэн бөгөөд ийнхүү хоёр талын харилцан ойлголцох явдал улам гүнзгийрэн, харилцаа хөгжих төлөв улам тодорхой болсонд Монголын олон нийт таатай байв.

МХНН-ийн төлөөлөгчид Бүх Хятадын гадаадтай найрамдах ардын нийгэмлэг, Хятад-Монголын найрамдлын нийгэмлэгийн урилгаар БНХАУ-д зочилж Хятадын ард түмний аж амьдрал, бүтээн байгуулалтын байдалтай танилцав. Хятад-Монголын найрамдлын нийгэмлэгийн дарга Жан Вэйле тэргүүтэй төлөөлөгчид 1986 онд Монгол-Хятадын найрамдлын нийгэмлэгийн урилгаар манай оронд зочилж Улаанбаатар, Эрдэнэт, Дархан, Сайншанд зэрэг хот, хөдөөгийн үйлдвэр, аж ахуй, соёлын байгууллага, ард түмний аж амьдрал, бүтээн байгуулалттай танилцлаа.

Хятадын Коммунист намын VIII их хурал хуралдсаны 30 жилийн ойд зориулан эрдэм шинжилгээний бага хурал хийж, уг их хурлын ач холбогдлын тухай илтгэл тавьсан юм.

МЭТНБХ-ны гүйцэтгэх хороо, МХНН нь БНМАУ-ын Ардын Их Хурлын урилгаар манай оронд зочилсон БНХАУ-ын Бүх Хятадын Ардын төлөөлөгчдийн их хурлын байнгын хорооны орлогч дарга Пэн Чүн тэргүүтэй төлөөлөгчдөд зориулан хүлээн авалт хийж, МЭТНБХ, МХНН-ийн үйл ажиллагааны талаар танилцуулав. Хятадын Ардын их хурлын төлөөлөгчид манай хороо, нийгэмлэгийн үйл ажиллагаанд талархаж байв.

МЭТНБХ-ны гүйцэтгэх хорооны дарга Д. Цахилгаан тэргүүтэй төлөөлөгчид БНХАУ-д Бүх Хятадын гадаадтай найрамдах ардын нийгэмлэгийн дарга Жан Вэньжин тэргүүтэй төлөөлөгчид БНМАУ-д зочилсон нь олон нийтийн байгууллагуудын дээд хэмжээний айлчлал болов.

МАХН-ын Төв Хорооны улс төрийн товчооны гишүүн, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга Б. Алтангэрэл, Жан Вэньжин тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч БНМАУ, БНХАУ-ын хоорондын харилцааг цаашид улам хөгжүүлэн бэхжүүлэх нь чухал бөгөөд энэ нь хоёр орны ард түмний эрх ашигт бүрэн нийцэхээс гадна нийтийн энх тайван аюулгүй байдлыг хамгаалахад нэмэр хандив болно гэж онцлон тэмдэглэв.

Энэ жил МХНН-ийн идэвхтний төлөөлөгчид ХМНН-ийн урилгаар БНХАУ-д зочилж БНХАУ-ын Нийгмийн ухааны академи, Бээжингийн их сургууль, Өвөр Монголын их сургуулийн үйл ажиллагаатай танилцаж, цаашид эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх арга замын талаар тодорхой санал бодлоо солилцлоо. Цаашид энэ яриа хэлэлцээг хэрэгжүүлэх талаар хоёр тал зохих алхмуудыг хийж эхлээд байна.

МЭТНБХ-ны гүйцэтгэх хороо, МХНН чухал үйл явдлыг тохиолдуулан БНХАУ-ын бүтээн байгуулалт болон хоёр орны харилцааг харуулсан гэрэл зургийн самбар гаргаж нийтэд үзүүлдэг. Түүнээс гадна Төв

аймгийн Лүн сумын Монгол-Хятадын найрамдлын нэрэмжит «Энхтуул» нэгдэл БНХАУ-ыг тунхагласны 38 жилийн ойгоор үдэшлэг уулзалт хийж тэмдэглэсэн бөгөөд БНХАУ-аас тус улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Ли Жүйчин, бусад дипломатууд өргөн оролцов.

Манай нийгэмлэгийн үйл ажиллагаанд БНХАУ-ын ЭСЯ-аас идэвхтэй дэмжлэг үзүүлж байгаад МХНН-ийн нийт гишүүд баяртай байдаг юм.

Хоёр орны харилцааг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлж байгаа МЭТНБХ-ны гүйцэтгэх хороо, МХНН болон Бүх Хятадын гадаадтай найрамдах ардын нийгэмлэг, ХМНН цаашид харилцаагаа хөгжүүлэх асуудлыг тус тусдаа боловсруулж байна.

МЭТНБХ-ны гүйцэтгэх хороо, МХНН нь 1989 онд ХМНН-ийн идэвхтний төлөөлөгчдийг хүлээн авах, МХНН-ийн идэвхтэн гишүүдийн эгнээг өргөтгөх, БНХАУ-ын ололт амжилтыг Монголын олон нийтийн дунд өргөн сурталчлах, өөрийн ард түмний амьдрал, бүтээн байгуулалтыг БНХАУ-д сурталчлах зэрэг ажлыг явуулахаар төлөвлөж байна.

Монгол-Хятадын ард түмний найрамдал, хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэхэд МХНН улам их нэмэр хандив оруулахын төлөө чармайн ажиллах болно.

## **МОНГОЛ-ЯПОНЫ ХАРИЛЦАА ҮҮСЭЖ ТОГТСОН НЬ**

О. ОЮУНГЭРЭЛ

1921 оноос хойш МАХН, Монголын засгийн газар дэлхийн бүх ард түмэнтэй энх тайвнаар амьдрах гэсэн монголын ард түмний хүсэл эрмэлзлийг илэрхийлэн, нийгмийн өөр өөр байгуулалттай улсууд энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын үндсэн дээр капиталист орнуудтай харилцаа тогтоох саналаа дэвшүүлэн тавьж байлаа. Гэвч хөрөнгөтөн орнууд, Монголын ардын засгийг хүлээн зөвшөөрч дипломат харилцаа тогтоохоос эрс татгалзаж байв.

Дайны дараах жилүүдэд хүчний харьцаа социализмд ашигтайгаар өөрчлөгдөхөд БНМАУ олон улсын тавцан дээр гарч ирэх боломжтой болов. Ялангуяа социалист хамтын нөхөрлөлийн гишүүний хувьд БНМАУ ын олон улсын хэлхээ холбоо өргөжихийн зэрэгцээ зарим хөгжиж байгаа ба хөрөнгөтөн орнуудтай харилцаа тогтоох болжээ.

Дипломат хэлхээ холбоогоо өргөжүүлэх гэсэн манай улсын чиг шугам Ази тив дэх олон улсын байдалд чухал ач холбогдолтой байв. Үүнтэй уялдуулан БНМАУ-ын засгийн газар Япон улстай албан ёсны дипломат харилцаа тогтоох чармайлт гаргах болсон юм. Хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоох явцад нэлээд бэрхшээл гарсан нь юуны өмнө Японы эрх баригчид АНУ-ын хомрогонд орж, БНМАУ-тай хоёр талын хэлхээ холбоо тогтоохоос янз бүрээр татгалзсантай холбогдож байв. Тухайлбал, Японы засгийн газар гоминданыхан Монголын газар нутаг руу өнгөл-